



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ЗӨВЛӨМЖ

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны III байр
Утас: 7011-1284, Факс: (976-11) 31-15-09
<http://www.ub.inspection.gov.mn>
E-mail: ub_info@inspection.gov.mn

2017.01.26 № 02-05-196/05
танай _____ -ны № _____ -т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайд уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа 3-аас дээш жил явуулаагүй зөрчил дутагдалд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

2016 онд хийгдсэн тандалт судалгааны үр дүнгээс харахад тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд ашиглалтын тусгай зөвшөөрөл авснаас хойш 3 жилээс дээш хугацаагаар уул, уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлээгүй байгаа нь Газрын хэвлийн тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Газрын тухай, Ашигт малтмалын, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулиуд болон "Нөхөн сэргээлтийн стандарт"-уудын талаар бүрэн судалж ойлгоогүйтэй холбоотой байна.

Иймд эрсдлээс урьдчилан сэргийлэх үүднээс дараах хууль тогтоомж, журмын заалтуудыг хэрэгжүүлж ажиллахыг ЗӨВЛӨЖ байна.

1. Газрын хэвлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.1 дэх /Газрын хэвлийг олгосноос хойш 3 жилийн хугацаанд ашиглаж эхлээгүй бол газрын хэвлий ашиглах эрхийг дуусгавар болгоно/ заалт
2. Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дах /Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч дараахь баримт бичгийг уурхай дээр байлгана/ заалт
3. Ашигт малтмалын тухай хуулийн 36 дугаар зүйл /Уурхайн талбайн хил тогтоох, шав тэмдэг тавих/
4. Ашигт малтмалын тухай хуулийн 37 дугаар зүйл /Байгаль орчныг хамгаалах/
5. Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.6.1 дэх /тухайн ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг эрх бүхий байгууллагаар хийлгэж ашиглалтын тусгай зөвшөөрөл авснаас хойш нэг жилийн дотор төрийн захиргааны байгууллагад ирүүлэх/ заалт
6. Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2012 оны 04-р сарын 17-ны өдрийн №074 дугаар

003198001082

7. тушаалаар батлагдсан Ашигт малтмалын баялагийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үдэслэл хүлээн авах журмын 7.3 /Уул уурхайн төсөлд хүчин чадал, техник, технологийн өөрчлөлт орсон, уг техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулснаас хойш ашиглалт явуулалгүй 3-аас дээш жилийн хугацаа өнгөрсөн....., төсөл хэрэгжүүлэгч байгууллага техник, эдийн засгийн үндэслэлийг тодотгох, шинчлэх буюу шинээр боловсруулах үүргийг хүлээнэ/-ийг хэрэгжүүлж ажиллана.
8. Тухайн жилийн дотоод хяналтын ажлын төлөвлөгөөг захирлаараа батлуулан, дотоод хяналтын төлөвлөгөөний дагуу хийсэн ажлын тайланг улирал тутамд гарган Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, геологи, уул уурхайн хэлтэст ирүүлж байх зэрэг баримт бичгийг бү
9. рдүүлэхийг зөвлөж байна.

ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ



Т.АМАРСАЙХАН